

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/83/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2021 он	Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn “Анализ старт аудит” ХХК-ийн Ахлах аудитор А.Батжаргал Утас: 99291595 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2022.02.25 № 97

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар ажиллагсад амралт, цалинг давхардуулан олгосон, авлагыг барагдуулалгүй хаасан, даргын тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал олгосон, хөрөнгийн тооллогыг ном журмын дагуу тоолоогүй, зардлын эдийн засгийн ангилал зөрүүтэй бүртгэсэн, нийгмийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөөгүй, батлагдсан төсөв хэтрүүлэн зарцуулсан, бичиг хэргийн зардлыг хэмнээгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй зэрэг 149.5 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

07020187

Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагч нь Боловсролын ерөнхий газрын дарга" гэсэн агуулгатай заалт оруулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 8 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 98 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	74,147.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	658,570.9
	Нийт хөрөнгийн дүн	732,718.7
	Нийт өр төлбөрийн дүн	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	732,718.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	732,718.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,518,665.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	785,808.7
	Үйл ажиллагааны үр дүн	732,856.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	137.7
	Үйл ажиллагааны нийт үр дүн	732,718.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-
	Тайлант оны үр дүн	732,718.7
	Эцсийн үлдэгдэл	732,718.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	823,014.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	769,275.6
	Үйл ажиллагааны ЦМГ	53,739.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-10,042.6
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	43,696.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43,696.3
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	687,830.5
	Урсгал зардал	687,830.5
	Хөрөнгийн зардал	0.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	731,526.9
	Улсын төсвөөс санхүүжих	726,326.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	5,200.2
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	43,696.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОНТ		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	87,647.3
	Урсгал зардал	87,647.3
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	87,647.3
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	87,647.3
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 6.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- ✓ Үр дүнгийн тайланд 3.4 сая төгрөгийн шатахууны зардлыг түлш халаалтын зардалд тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.
- ✓ Төсвийн хэлбэлзэл 3.3 сая төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 190.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 18.7 сая төгрөгийн 1 заалт бүхий хариуцлага тооцох албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 171.1 сая төгрөгийн 7 заалт бүхий албан шаардлага, 2 заалт зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Тайлант он буюу 2022 оны 11 дүгээр сард ажиллаагүй 2 хүнд 0.2 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Цалингийн урьдчилгаа 0.1 сая төгрөгийг төлүүлээгүй шууд хаасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажилчдад 0.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг тушаал шийдвэргүйгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.11-т "Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана."

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Нийгмийн даатгалын тайланд ажилчдын 2.0 сая төгрөгийн цалинг дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаасны зардлыг хэмнээгүй 0.4 сая төгрөгийн бичгийн цаасыг өмнөх оноос илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Байгууллагын гэрэл цахилгааны төсвийг 0.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх" заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Хөрөнгийн тооллогын дүн нягтлан бодох бүртгэлийн дүнгээс 124.2 сая төгрөгөөр зөрүүтэй.нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх"; заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Зардлын зүйл анги зөрчиж 0.4 сая төгрөгийн урсгал засварыг цэвэр, бохир усны зардлаас, 0.7 сая төгрөгийн номын түрээсийн орлогыг Улсын төсвийн санхүүжилтэд, 2.1 сая төгрөгийн хоолны зардлыг үдийн цайны зардлаас зарцуулсан. Энэ нь төсвийн хэлбэлзэл зөрүүлсэн нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 9.6 сая төгрөгийг дутуу шивсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд

холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 31.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Түлш халаалтын зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь "Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Хариуцлага тооцох албан шаардлага


- ✓ Даргын тушаал шийдвэргүйгээр 18.8 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон. Үр дүнгийн урамшуулал олгох даргын тушаалыг үзэхэд захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний А/05, 03 дугаар 25-ний өдрийн А/07 дугаар тушаалуудын хавсралтыг нөхөж бүрдүүлсэн, 2022 оны 09 дүгээр сарын 14-ний А/27 дугаартай тушаалын хавсралтыг сольж 12 дугаар сарын үр дүнгийн урамшуулал олгосон. Энэ нь захирлын тушаалын баримтад байхгүй хуурамчаар үйлдсэн. 2022 оны 11 дүгээр сард тушаалгүй урамшуулал олгосон бөгөөд 4 дүгээр улирлын урамшуулал гэж нягтлан бодогч тайлбарлаж байгаа нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.9-т "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах"; 20.2.11-т "өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах арга хэмжээ авах"; Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заалтыг нийцсэн бөгөөд бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс түүвэрчилж үзэхэд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 35 мэдээлэл шийдвэрийн хуулбарыг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах



мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

2. Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажилчдын илүү цагийн нэмэгдлийг олгохдоо дундаж цалин хөлсийг тооцож бодоогүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1-т "Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/192 дугаар тушаалын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.2-т "Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын цалин хөлсөөр тооцно", заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Илүү цагийн нэмэгдлийг олгохдоо дундаж цалин хөлсийг тооцож бодох Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургууль	2	6.7	-	-	2	6.7	2	6.7	-	-	-	-
Дүн	2	6.7	-	-	2	6.7	2	6.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын	9	149.4	3	0.5	4	148.9	-	-	1	1	-	-

Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургууль												
Дүн	9	149.4	3	0.5	5	148.9	-	-	1	1	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/сая төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургууль	1	0	-	-	-	-	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургууль	3	40.9	-	-	2	40.9	1	-
Нийт дүн	4	40.9	-	-	2	40.9	2	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-